

Манмин Мэдээ

№ 79 2019 оны 12 сарын 22

“Эзэний үг миний хөл дэх дэнлүү, миний зам дах гэрэл юм”

19-р дугаар Сургаал үгийн тэмцээн,
эцсийн шалгаруулалтад 59хүн үлдэж өрсөлдлөө



10-р сарын 27ны Эзэний өдрийн үдээс хойш мөргөлөөр 19дэх удаагийн сургаал үгийн тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа болж өнгөрлөө. 8-р сарын 25нд 1-р үед 2100хүн оролцож, 2-р үед 97хүн шалгарч үлдсэнээс эцсийн шалгаруулалтад 59хүн үлдэж 9-р сарын 29ний өдөр сургаал үгээр өрсөлдлөө.

Тэмцээний дүн гарч тэргүүн байрыг Дежон манмин сүмийн Пак Хүн ён пастор эзэлж, цом болон ариун

аялалын эрхийн бичгээр шагнуулав. Алтан медалийг Ким Хён жү номлогч (3-р их бүлэг 23-р хэсгийн ахлагч), Мөнгөн медалийг Хо Нам сүг номлогч (Дежон), Гу Гён сог сүмд үйлчлэгч, (2-1 Эрэгтэйчүүдийн баг), Ан Ге хён сүмд үйлчлэгч (Дежон), Хүрэл медалийг Шин Мён шиг сүмд үйлчлэгч (4Канаан баг), Ким Жун өн сүмд үйлчлэгч (Дежон), тусгай байрын шагналыг Ким Ил дү сүмд үйлчлэгч болон бусад 19хүн, нийт 31хүнд урамшуулал

болон дурсгалын зүйлээр шагналаа.

Мөн энэ жилийн тэмцээний багийн дүнгээр, орон нутаг, салбар сүм зэрэг хэсгээр хуваарилан шагнаж урамшуулаа. Хэсгийн үнэлгээгээр 1-р байрт Хятадын 2-р хэсэг, багийн үнэлгээгээр 1-рт 5-р Канаан баг, салбар сүмийн үнэлгээгээр Дежон манмин сүм үзэлсэн бөгөөд тус бүр шагнагдлаа.

И Жей руг тэргүүн пастор үргэлж 'Бурханыг хайрлаж, Эзэний зүрх сэтгэлийг дуурайх нь итгэлийн амьдралын

суурь бөгөөд миний дотор Бурханы үг байж Ариун Сүнсний дуу хоолойг сайн сонсож, ариун байдлыг бий болгох боломжтой' гэж захидаг юм. Ялангуяа 2000оноос хойш Бурханы үгийг сүнсээр зэвсэглэхээс гадна, өдөр бүр библийн нэгээс дээш бүлэг уншиж, нэг ишлэл цээжлэхийг захидаг тул Эрэгтэйчүүдийн багаас итгэгч нарын сургаал үгээр зэвсэглэхэд дөхөм болох үүднээс сургаал үгийн тэмцээн зохион явуулж ирсэн ба энэ жил 19дэх удаагаа үргэлжлэн явагдлаа.

ЭНЭТХЭГИЙН ТӨВ ХЭСЭГТ 'GCNTV HINDI' СУВГИЙН ҮЗЭГЧ НАРТ ЗОРИУЛСАН СЕМИНАР



9-р сарын 30наас 10-р сарын 4ныг хүртэл 4шөнө 5өдрийн хугацаатай Ким Сан хи пастор (Энэтхэг, Дели Манмин цуглаан) 'GCNTV HINDI' сувгийн үзэгчид рүү хандсан сайн мэдээний томилолтоор яваад ирсэн юм. Энэтхэгийн төв хэсэг Матиа Прадешин муж, Латиранаас Индүри, Шагари хүртэл нийт 1954км замыг туулан, айл эргэлт болон семинар удирдан явууллаа.

'GCNTV HINDI' нь Энэтхэг хинди хэлээр цацагддаг юүтүбэ суваг бөгөөд И Жей руг пасторын чухал сургаалийг нэвтрүүлдэг юм. Энэ сувгаар дамжуулан олон номлогч нар, үзэгчдэд дамжуулагдах төдийгүй гэр цуглаан, болон салбар сүмүүд бий болж эдгэрлийн хүч нөлөө байнга илрэн гарсаар байгаа юм (4-нүүрний гэрчлэлүүд үзэх).

Латирам гэдэг газарт 'GCNTV HINDI'г үзээд ивээл авсан нэгэн номлогч итгэгч нартаа И Жей руг пасторын сургаалийг дамжуулж байгаа бөгөөд Индүри 'GCNTV HINDI' үзсэн үзэгчид цугларч манмин салбар сүмийг байгуулсан байв. Мөн Шагари мужид эдгэрэл авсан итгэгч нар семинар хийхийг урьснаар энэ удаагийн томилолтын ажил эхэлсэн юм.

Ялангуяа 8-р сард Юүтүбээр дамжуулан И Жей руг

пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) аар залбирал авч эргэн сэргэсэн Анкуш Нелсон итгэгчийн гэрт зочилсон бөгөөд тэрээр маш сайжирсан байгааг олж харсан юм. Анкуш итгэгч нь авто ослын улмаас биеийн зүүн тал саажсан бөгөөд огт ухаангүй байдалтай эмнэлэгт удсан байсан юм. Гэвч эхнэр нь 'GCNTV HINDI' холбогдож, шууд дамжуулагдаж буй Манмины зуны цуглаанаар дамжуулан нөхөртөө залбирал авахад маш гайхалтайгаар тэр агшинд эдгэрсэн юм. Үүнээс хойш түүний саажсан хэсэг эргэж мэдээ орж, эхнэр нь ажилд хүртэл орсон байлаа.

Шагари муж 70орчим хүн цугласан семинари бий болсон юм. 'GCNTV HINDI'р дамжуулан манай цуглааны эдгэрэл ивээлийн цуглаанд оролцсон Моника итгэгч уушгины хүнд өвчнөөсөө эдгэрч, авто ослын улмаас бэртсэн Рита итгэгч эдгэрсэн зэрэг эрх мэдэлт хүчний нөлөөг үзсэн хүмүүс хүсэн тэмүүлэн оролцож тэд нар ч их ивээл авсан цаг байлаа.

Мөн Ким Сан хи пастор нь явсан газр болгондоо Бурханы үгийг тунхагласаны дараа эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирч өгөхөд атгаг сүнснүүд зайлж, саажилт хорт хавдар, зэрэг төрөл бүрийн өвчин эдгэрч Бурханд алдрыг өргөж байлаа.

“Цөснийн үрэвсэл өвчнөөсөө бүрэн эдгэрч шинээр амьдарч байна!”

Притима Дэби итгэгч
(33нас, Энэтхэг, Ута Прадешин муж Барана хот)

2017оноос яагаад ч юм бие маань тавгүйрхэж, хэвлий хэсгээр өвддөг байлаа. Тухайн үед ходоодны шарх гэж бодож байсан юм. 2019оны 1-р сараас эхлэн маш хүчтэй өвддөг болж, өвдөөд эхлэвэл 4-5цагын турш өвдөж, цаг агаар сэрүүн үед хөлрөх хэмжээний маш хүчтэй өвддөг байлаа.

Эмнэлэгт очин шинжилгээ хийлгэхэд дотор өөхлөлттэй зүүн талын бөөрөнд асуудалтай, мөн 8.3мм голчтой цөсний чулуутай гэсэн юм. Эмч хагалгаанд орох ёстой гэсэн ч надад хагалгааны төлбөр хийхэд хэцүү байсан тул зүгээр тэвчсээр л байсан юм.

Гэвч гэдэс хэвлийгээр өвдөх өвдөлт үгээр илэрхийлэх аргагүй болов. Төрөх өвдөлтөөс илүү их өвдөх байдалтайгаар өдрийг өнгөрөөж ингэж байгаад үхэх байх гэж бодож байлаа. Цаг өнгөрөх тусам бие минь дордож, гэрийн ажлаа ч хийж чадахгүй бүх бие нүүр хүртэл хавагнаж, сулбагардуу суух юмуу хэвтдэг байлаа.

Тэгтэл Жи нин Сунита эгч дүү ‘GCNTV HINDI’ юүтуб сувгийг надад зааж өгсөн юм. Үүгээр дамжуулан И Жей



руг тэргүүн пасторын сургаалийг сонсонгоо бие маань дээрдэж байгааг мэдэрсэн юм. Ялангуяа сургаалийн дараа тэргүүн пасторын залбирлыг авсаны дараа бие минь хөнгөрч, эдгэрч чадна гэсэн бат итгэлтэй болсон юм. Тэгж байгаад Манмин төв сүмийн 3-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд ‘GCNTV HINDI’-р оролцож

залбирал авсан боловч эдгэрч чадаагүй юм.

Тэр үед би сүмд явдаг ч хиймэл шүтээнд үйлчилдэг байсан ба тэргүүн пасторын сургаалийг үргэлжлүүлэн сонсож, хиймэл шүтээнийг хаях хэрэгтэй тухай ухаарсан юм. Шууд тэр бүгдийг хаяад оролцсон 4-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд залбирал авах

хүчтэй өвдөлт нь байхгүй болж гэрийн ажил хийх боломжтой болсон юм. Хаван ч нэлээн багасаж, бие маань ч өмнөхөөсөө дээрдэж, эмнэлэгт үзүүлтэл бөөрний өвчин хэвийн болж, цөсний чулуу ч багассан болохыг олж мэдсэн юм. 5-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд залбирал авсан дараа бага зэрэг үлдсэн өвдөлт бүрэн арилсан юм.

Мөн ‘GCNTV HINDI’-р дамжуулан тэргүүн пасторын залбирлыг маш олон авахад бага багаар сайжирч нэг л мэдэхэд бүрэн эдгэрсэнээ мэдсэн юм. Тэгээд сүүлд 10-р сард эмнэлэгт үзүүлтэл “Эмч бүх зүйл хэвийн байна. Дахиж ирэх шаардлаггүй” гэсэн баярт мэдээ сонссон юм. Халлелүяа!

Эзэнт итгэдэггүй нөхөр маань ч би өвчнөөсөө эдгэрч, өөрчлөгдөж байгааг хараад долоо хоног болгон, юүтүбээр Манмин төв сүмийн мөргөлд оролцож, бидний амьдарч буй Баран хотод манмин цуглаан эхлэх гээд бэлдэж байгаа юм. Илүү олон хүмүүс эдгэрч, хариулт аваад, надтай адил шинэ амьдралаар амьдрахын төлөө залбирч байна. Сайн Бурхан Аавдаа бүхий л талархал ба алдрыг өргөө.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан: power3712@gmail.com

‘Сүнслэг хайр’ цуврал 9

Хайр бол уурладаггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.”

1 Коринт 13:4-5

И Жей руг тэргүүн пастор

Хайр бол хүний сэтгэлийг өөдрөг болгодог ч уурлах нь хүний сэтгэлийг шархлуулж, өөдрөг бус уруу дорой болгож, мөн Бурханы хайраас холдуулдаг юм. Дайсан сатан диавол Бурханы хүүхдүүдийг уурлах байдлаар бүдрүүлж унагаадаг.

Дайсан сатан диавол Бурханы хүүхдэд тавьдаг гол урхи занга нь үзэн ядалт болон уур хилэн юм. Уурлана гэдэг нь зүгээр л уцаарлаж, чанга дуугаар харааж, хүч хэрэглэх явдал биш юм. Нүүр царай барайж, ширүүн төрхтэй болох, үг яриа хатуу болох нь далд байдлын уур юм. Тухайн хэр хэмжээнээс хамаарч зүрх сэтгэл дэх үзэн ядалт, бухимдал илэрхийлэгдэж байдаг. Тийм байлаа ч бусдын дүр төрхийг хараад ‘Ууртай байгаа юм байна’ гэж дүгнэж болохгүй юм.

Есүс Бурханы өргөөнд худалдаа хийж байсан хүмүүсийг хөөж байсан удаа бий. Дээгүүр өнгөрөх баярт бэлдэхээр Иерусалимын сүмд цугларсан хүмүүст сүмийн хашаанд өргөлийн мөнгө солих, тахилд өргөх мал амьтадыг зарж, мөн авч байлаа. Маргалдаж муудалцдаггүй, хэн ч Түүнийг замд өндөр дуу гаргаж байгааг үзээгүй хэмжээний дөлгөөхөн Есүс энэ байдлыг хараад гэнэт өөрчлөгдсөн юм.

Дээсээр ташуур хийж мал амьтадыг хөөж, мөнгө солигчдын ширээ болон тагтаа худалдаж буй худалдаачдын ширээг хөмөрч орхисон юм. Хүмүүсийг харахад уурлаж байна гэж бодох ч энэ

Есүс үзэн ядалтын улмаас бус худалдаачдын үйлдлийг буруутган зэвүүцэн хилэгнэсэн үйлдэл байлаа. Хэдийгээр худалдаачид зөв зорилготой ийм юм хийдэг байлаа ч Бурханы өргөөг бохирдуулах нь эцэстээ уучлагдахгүй үйлдэл гэдгийг ухааруулж өгсөн юм. Энэ нь хуулийг хайраар төгс болгож буй Бурханы хайраас үүдэлтэй юм.

1. Хилэгнэл ба уурлахын ялгаа

Марк номын 3-р бүлэгт үзвэл Есүс синагогт нэг талын гар нь хатингар болсон хүнтэй уулзсан юм. Тэр өдөр нь амралтын өдөр байсан тул хорон муу хүмүүс Есүсийн байдлыг харах гэж хэрэв өвчтэй хүнийг эдгээвэл амралтын өдрийг зөрчсөн гэж буруутгахын төлөө сорьж байлаа.

Есүс тэднийг сэтгэлийг мэдэж байсан тул “Амралтын өдөр сайныг хийх ба хорон мууг хийх нь, амийг аврах ба хороох нь аль нь зөв үйлс вэ?” гэж асуусан байдаг (Марк 3:4). Тэд нар юу гэж хариулахаа мэдэхгүй Есүсээс тэд нарын атгаг байдалд сэтгэл нь өвдөн хилэгнэж, тэдний тойруулан харангаа өнөөх хатингар гартай хүнд хандан гараа сунга гээд гарыг нь эдгээж өгсөн юм (Марк 3:5).

Зөвхөн сайныг үйлддэг Есүсийг шүүж, хорлох гэсэн тэдэн рүү хандан Есүс маш хатуу зэмлэн яадаг ч байсан гэмээс нь эргүүлэхийг хүсэж байлаа. Заримдаа хилэгнэхдээ ч хүмүүсийг ухааруулж, амь руу удирдахын төлөө хайраас үүдэлтэй юм.

Энэ мэт хилэгнэх ба уурлах нь

огт өөр утгатай юм. Тэр хэмжээний ариун болон гэмгүй болох тусам хилэгнэл, зэмлэлээр дамжуулан хүмүүст амийг өгөх үйлс бий болдог. Эсрэгээрээ зүрх сэтгэлд хорон муу байвал сайн үрж жимс гарах боломжгүй юм.

2. Хүмүүс уурладаг гол шалтгаан

Юуны өмнө өөрийн бодол, сэтгэлд нийцэхгүй учраас юм. Хүг болгоны өссөн орчин, сурсан мэдлэг өөр тул сэтгэл санаа, бодол нь өөр, хүмүүжил болон дүгнэх жиших хэмжүүр өөр байдаг мөртлөө бүх хүмүүсийг өөртэйгөө нийцүүлэх гэх учраас сэтгэл тавгүйтэл үүсдэг.

Мөн өөрийг нь дагахгүй, дуулгаваргүй байх үед уурлах тохиолдол бий. Өөрийгөө бусдаас илүү гэж бодох юм уу илүү дээр байр сууринд байвал дуулгавартай дагахыг хүсдэг. Мэдээж дээр байр суурьтай хүнийг хүндэлж, дэг журмын дагуу дагаж өгөх нь ч зөв ч дуулгавартай дагахыг шаардах нь зохисгүй явдал юм. Доор ажилладаг хүнийхээ үгийг огт сонсох ч үгүй, өөрийн хүслээр дагуулахыг хүсэх тохиолдол ч бий.

Үүнээс гадна өөрөө хохирол амсах юмуу, хилс хэрэгт холбогдох үед ямар ч шалтгаангүй гоморхолыг сонсох юмуу, тийм зүйлд автах үед өөрийн үүрэг болгосоны дагуу хүссэний дагуу болохгүй үед хэн нэгэнээс бүдүүлэг хараалын үг сонсох юмуу доромжлуулах үед амархан уурладаг болохыг харж болно.

Ихэнх хүмүүс уурлахын өмнө сэтгэлдээ тавгүйтэл бухимдалыг мэдэрдэг. Бусдын үг ба үйлдлээс эхлэн тавгүйтэж, хураагдсаар эцэстээ уурлах үйлдлээр ил гарч ирдэг байна. Ихэнхдээ ‘Бухимдаж байна. Тавгүй байна’ гэх нь уурлахын босгон дээр байна гэсэн үг юм. Бид уурлавал Бурханы хайранд дотор байх болох боломжгүй бөгөөд сүнслэг өсөлтөд том саад болдог юм.

Муухай мэдрэмж тавгүйтэл байгаа цагт үнэнээр өөрчлөгдөх боломжгүй тул харамсах юм хийхгүй нь тулд уур бухимдлаа хаях хэрэгтэй юм. Ариун Сүнс бидний сэтгэлийг Өөрийн орших өргөө болгосон тул (1 Коринт 3:16). Бурхан бүгдийг харж байгааг ухаарч өөрийн бодол санаанд нийцэхгүй байна гээд уурлах явдал байхгүй байх хэрэгтэй юм.

3. Бурханы зөвт байдлыг биелүүлдэггүй уур хилэн

Хойд Израйлийн эш үзүүлэгч Елиша өөрийн багш Елиагаас хоёр дахин илүү эрх хүч эрх мэдэлт хүчийг үзүүлдэг хүн юм.

Хүүхэдгүй эмэгтэйд хүүхэдтэй болох ерөөл өгч, үхсэн хүнийг амьдруулж, уяман өвчинг эдгээж, залбирлаар дайсныг хөөх зэрэг гайхамшигтай Бурханы эрх мэдэлт хүч илрэн гарч байна. Уухад хэцүү усанд давс хийж сайн ус болгосон. Гэсэн ч тэрээр эш үзүүлэгч хүн ч гэсэн өвчнөөр өөд болсон юм. Яагаад тэгсэн юм бол?

Тэрээр Бетел рүү явж байх замд юм. Нэг хэсэг хүүхдүүд тэр орчмын тосгоноос цугларч Елиша эш үзүүлэгчийн тойрон зогсоод “Халзан толгойтоо чи дээшээ яв, Халзан толгойтоо чи дээшээ яв” (Хаадын дэд 2:23) гэж шоолцгоож

байлаа. Ганц хоёр хүүхэд ч биш нэлээд тооны хүүхдүүд энд тэндээс нь доромжлон шоолцгооход Елиша яахаа мэдэхээ байсан юм. Аргадаж нэг үзээд, чанга дуугаар зэмлэж үзсэн юу өөрчлөгдөхгүй байлаа. Тэд болих янзгүй байн дахин хашхиралдаж буй хүүхдүүдийн дуу хоолой тэсэхэд маш хэцүү, зовлонтой байлаа.

Бетел Израйл хуваагдахад хойд Израйлийн хиймэл шүтээний үүр уурхай болсон газар юм. Түүний зэргэлдээ тосгоныхон иймэрхүү байдалд байсан тул тэдний зүрх сэтгэл тэр хэмжээгээр хатуурсан гэсэн үг юм. Замыг хаан зогсоод нулимж харааж, бүр чулуу шидэлсэн ч байж болох юм. Тэгээд Елиша эцэстээ тэсч чадалгүй хүүхдүүдийг хараахад тэдний ойролцоо байсан хоёр эм баавгай хүүхдүүд рүү дайрч 42хүүхэд тэндээ үхэцгээсэн юм.

Энэ үйл явдал хэдийгээр хүүхдүүдийн тэсэхийн аргагүй доромжлолоос болсон ч Елишагийн төгс байж чадаагүй дүр төрхийг харуулж байгаа юм. Тэрээр өвчин тусч үхсэн нь үүнтэй хамааралгүй ч Бурханы хүүхдүүд уурлах нь зохисгүй үйлдэл гэдгийг ухааруулж буй хэрэг юм (Иаков 1:20).

4. Уурлалгүй хайрыг бий болгохын тулд

Пүршийг түлхэх тусам илүү их тэлэх хүч үүсч гараа авах үед агшин зуур тэлж үсэрч оддог. Уурыг барьж тэвчих ч мөн адил юм. Зүгээр л барьна гэдэг нь тухайн үеийг өнгөрөөсөн ч хэзээ магадгүй тэсэрч болзошгүй юм.

Тиймээс би уурлалгүйгээр хайрыг бий болгохын тулд уурлах уцаарлах гэдэг зүйлийг хаях хэрэгтэй юм.

Албаар барьж тэсэх бус, тэсэх юм байхгүй болтол сэтгэлээ сайн болон хайраар дүүргэх хэрэгтэй юм.

Мэдээж нэг өдрийн дотор бүгдийг хаяад сайн болон хайраар дүүргэн гэсэн үг биш юм. Өдөр бүр тууштай хичээх хэрэгтэй юм. Хамгийн эхэнд уурлах нөхцөл байдалд тулаад ирвэл залбирлаар Бурхандаа даатгаж, өнгөрөөх дасгал хийх ёстой юм. Уурлах үедээ ‘Одоо ингэж уурлах ямар ашигтай билээ?’ гэж эргэцүүлэн бодохыг хүсье.

Энэ залбирч, Ариун Сүнсний тусламжтайгаар тэвчин өнгөрүүлсээр байтал уурлуулахад хүргэх тавгүйтэл хүртэл бага багаар хаягдах юм. Өмнө нь арван удаа уурласан бол ес, найм гээд багасаж ирдэг. Дараа нь хичнээн уурлах юм тохиолдсон ч сэтгэл тайван байж чадах юм (Сургаалт үгс 12:16, 19:11).

Хайрт итгэгч та бүхэн,

Амьд оршдог Бурхан хэзээд хаанаас харсаар байгаа бөгөөд бидний үг болгоныг, бодлыг ч бүгдийг мэддэг билээ. Бидний сэтгэлийн өргөө болгон орших Бурхан Аавын өмнө үргэлж, ариухан үг ба үйлсээрээ амьдарсан ерөөлтэй итгэгч нар болохыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
<http://www.manmin.org/english>
www.manminnews.com
e-mail: manminminen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Эзэний зам мөрийг дагаад (3)

“Зургаан өдрийн дараа Есүс Петр, Иаков болон түүний дүү Иохан нарыг дагуулан хэдүүлхнээ өндөр ууланд гарчээ. Тэр тэдний өмнө хувирч өөрчлөгдөв. Түүний нүүр нар мэт гэрэлтэж, хувцас нь гэрэл мэт цагаан болсон байлаа.” (Матай 17:1-2)



Гайхалтай уур амьсгал мэдрэгдэх Эзэн гэрэлтсэн уул

Матай номын 17-р бүлэгт гардаг Есүс гэрэлтдэг уул нь Петр болон Иаков, Иоханыг дагуулан хэдүүлхнээ гарч залбирал хийсэн газар юм. Энэ үе Есүс сүнслэг биеэр хувирч, Мосе, Елиа эш үзүүлэгч нартай уулзан сүнс талын гүн зүйлийг ярилцаж байлаа.

Түүний дотно шавь энэ үзэгдлийг хараад “Эзэн Таныг хэрэд хүсвэл, энд гэрван цацар барьж өгье. Нэгийг нь Танд, нэгийг нь Мосед, нэгийг нь Елиад зориуль” гэхэд гэрэлт үүл тэднийг бүчин авч тэр үүлэн дотроос “Энэ бол Миний хайрт Хүү мөн. Түүнд Миний таалал оршдог. Түүнийг сонсогтун” гэсэн дуу гарлаа библид бичигдсэн байдаг.

Израйлийн хөндийд байдаг далай түвшнээс 588 метрт орших, гэрэлтдэг уул нь энгийн сүүдрэвч гурав байтугай түүнээс ихийг барьж чадах тэгш талбайтай юм. Гэрэлтдэг уул нь Есүсийн тухайн үед сүнслэг уур амьсгал, гэрлүүд болон дуу хоолой мэдрэгдсэн газар юм.

Хармегдон дайныг санагдуулах Мигид

Өндөр гэгдэх гэрэлтдэг уулнаас цааш хөдлөн

явахад Хармегдон дайныг санагдуулах Мигид болон Газар дундын тэнгисийн эрэг орчмын нутгаар дайран өнгөрч Кайсари дамжин Иерусалим руу чиглэн явлаа.

Мигид нь Хойд Сирийн бүс нутаг ба Египетийн өмнөд хэсэгтэй хиллэдэг ба газар нутгийн төлөөх маш их дайн тулаан болсон газар юм.

Иошуа В.С. 1230 онд Израйлийн ард түмнийг дагуулан Иордан голыг баруун эргийг эзэлж Мигид бүс нутгыг ч мөн эзлэсэн юм. Соломон хааны үед Мигид ихэд хөгжсөн бол В.С. 723 онд Ассирын цэрэгт эзлэгдэн мөхсөн юм.

Кайсариар дамжин Иерусалим хүртэл



Кайсари нь Херод хааны бий болгосон Газар дундын тэнгисийн эргийн боомт хот юм. Боомт хот усан боомт, худалдааны газар, дугуй хэлбэрийн театр, маш нарийн хийц бүхий барилгын туурь олдворууд нь тухайн үеийн барилга хот байгуулалтын уран чадварыг илтгэж байгаа юм.

Кайсари хотоос эртний олдворын эрдэмтэд археологчдын олсон чулуун дээр “Иудейн захирагч Понти Пилат” гэсэн бичигтэй хөшөө байсан юм. Есүсийг шүүсэн Пилат боомт хот болох Кайсарид амьдардаг байсан гэх нотолгоо ч болдог гэнэ.



нулимс одоо ч мэдрэгдэх газар бөгөөд Есүсийн загалмай Түүнийг амиа алдахад гашуудах Магдалийн Мариа, онгон Мариагийн дуу сонсогдох мэт.

Ариун газар Иерусалимын гудамжинд цэгцтэй хувцасласан Иудей хүмүүсийг харж болох ч харамсалтай нь тэднээс ивээлийн гэрэл олж харахын аргагүй харанхуй сүүдэртэй нүүр царай хувцас болон малгай нь хар өнгөтэй байлаа.



Үйлс номын 10-р бүлэгт Кайсариг захирч байсан Ромын цэргийн зуутын дарга Корнел элч Петрийг өөрийн гэртэй урьж Бурханы үгийг сонсч гэр бүл болон найзуудтайгаа Ариун Сүнснийг авч харь хэлээр ч залбирч, баптисм авч байсан тэмдэглэл байдаг.

Эцэст нь хүрч ирсэн Израйлийн нийслэл Иерусалим нь тэр чигтээ харанхуйлсан мэдрэмжээр дүүрэн байлаа. Есүсийн Иерусалимруу хандсан



Tel: 82-2-824-7107
www.gcntv.org
webmaster@gcnetv.org



Tel: 82-2-818-7334
www.manminseminary.org
manminseminary2004@gmail.com



Tel: 82-2-818-7039
www.wcdn.org
wcdnkorea@gmail.com



Tel: 82-70-8240-2075
www.urimbooks.com
urimbook@hotmail.com

“Нүдний хараа 2.0, 1.5 сайжирсан”

Хуан Гим ран номлогч (56нас, Хятадын бүлгийн ахлагч)

Би тийм ч нүдний хараа сайтан хүн биш юм. 2014онд жолоонийн үнэмлэх авах эрүүл мэндийн үзлэгээр нүдний хараа 0.5, 0.3 байгааг мэдэж ялангуяа баруун нүдний ойрын хараа маш муу ба нүдний шил зүүсэн мөн л адил бүүдгэр давхарлагдаж харагдаж байлаа.

Мөргөлийн үед И Жей руг тэргүүн пасторын өвчин залбирлыг авах болгондоо гараа нүдэн дээр тавин залбирал авч, Бурханаас хариулт авахын төлөө залбирч байлаа. Тэгж байгаад 2016оны 8-рсард Манмин төв сүмийн зуны цуглаанд тэргүүн пасторын залбирлыг авсаны дараа цаг өнгөрөх тусам бага багаар харагдах бүх зүйл тодорсоор байлаа.

Тэр жилийн 11-р сард нүдээ үзүүлэхэд 1.5, 0.9 илэрхий сайжирсан болохыг мэдсэн юм. Нүдний шил хийхгүй байсан ч мөргөлийн дэлгэцийн жижиг бичгийг ч сайн хардаг болсонд маш баярлаж байлаа.

Тэгтэл 2019оны 7-р сард дахин нүдээ үзүүлэхэд бүр их гайхширсан юм. Нүдний хараа 2.0, 1.5 болж өмнөхөөсөө илүү сайжирсан байлаа. Халлелүяа!

Бурхан Ааваас гэнэтийн том бэлэг авсан мэт санагдаж, ‘Миний сэтгэлийн үнэрийг баяртайгаар хүлээн авчээ’ бодсон юм.

Би өнгөрсөн 4-р сараас эхлэн төрөл бүрийн сүмийн хүнд хэцүү асуудлаас болоод ‘Явал Бурханыг баярлуулах вэ’ гэж эрэн хайсаар байсан юм. Эзэний боолын хувьд сүмдээ хүч болохын төлөө надад даалгаж өгсөн итгэгч нараа алдах битгий хэл сэргэх ёстой гэсэн сэтгэл төдий л байлаа.

Талархалтай нь Хятадын бүлгийн итгэгч нар одоо ч нэг сэтгэлээр нэг хүслээр халуунаар зүтгэж ирсэн бөгөөд үүрэг албаа эрхэмлэн итгэгч нараа халамжилж тусалж, тасралтгүй сайн мэдээ тарааж, итгэмжтэй ажилтнуудын хүчээр харин ч их сэргэлт олсон юм. Энэ бүх зүйл Эзэний ивээл юм.

Манминд итгэлийн амьдралаар амьдарч ирсэн өнгөрсөн 35жилийн турш үргэлж сайн зүйлээр хамтдаа байж, Эзэний боол болж хүмүүсийн төлөө амьдрах хамгийн ерөөлтэй замаар замчилж өгсөн хайртай Бурхан Аавдаа, Эзэндээ бүх алдар талархалыг өргөө.



Шинжилгээний хариу

시각-청각 이상	시력(좌/우) 1.5 / 0.9	<input type="checkbox"/> 교정	청력(좌/우) 정상 / 정상	2016он
01105018	황금란님			
구분	목표질환	검사항목	결과 (참고치)	
계측 검사	비안/복부비안	키 (cm) 및 몸무게 (kg)	<input type="checkbox"/> 저체중 (18.5미만) <input checked="" type="checkbox"/> 정상 (18.5-24.9) <input type="checkbox"/> 과체중 (25-29.9) <input type="checkbox"/> 비만 (30이상)	
	시각이상	시력(좌/우)	<input checked="" type="checkbox"/> 정상 <input type="checkbox"/> 교정	
	청각이상	청력(좌/우)	<input checked="" type="checkbox"/> 정상 <input type="checkbox"/> 전완이상	2019он